



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 04 сарын 17 өдөр

Дугаар В/49

Хэрлэн сум

**Б.Онончимэгт буцалтгүй
тусламж олгох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, аймгийн Засаг даргын Тамгын газрын "Дотоод журам"-ын 7 дугаар зүйлийн 7.13 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн Баярсайханы Онончимэг нь шинэ хүүхэдтэй болсон тул байгууллагын дотоод журмын дагуу 50,000 (тавин мянга) төгрөгийн буцалтгүй тусламж олгосугай.

2. Буцалтгүй тусламжид шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын тэтгэмж, урамшууллын зардлаас санхүүжүүлэхийг Нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ж.ГАНБААТАР